

“Зам, үнэн, амь бол Би байгаа юм”

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Есүс Христ бол “зам, үнэн, амь” (Иохан 14:6) мөн

Иохан 14:1–6-г уншаад, Аврагч Өөрийг нь дагадаг хүмүүст хэрхэн туслахаа амласан болохыг олж мэд.

- Аврагч эдгээр шүлэгт ямар үнэнийг заасан бэ?
- 6-р шүлэгт Аврагч Өөрийгөө хэн гэж нэрлэсэн бэ?
- Эдгээр нэр цол бүр танд Есүс Христийн тухай мөн Түүнтэй харилцах харилцааны тань талаар юу зааж байна вэ?

Хэрэв та өмнөх хичээлээр Есүс Христийн янз бүрийн нэр цол, үүргийн талаар жагсаалт үүсгэсэн бол уг жагсаалтдаа Иохан 14 дээр нээн илрүүлсэн зүйлсээ нэмэх боломжтой. Мормоны Ном нь Шинэ Гэрээнээс таны суралцаж байгаа зүйлсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ. Мозая 3:17-г уншаад, энэхүү шүлэг нь Иохан 14:6-г илүү сайн ойлгоход бидэнд хэрхэн тусалж байгаа талаар эргэцүүлэн бод. Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч асан Дийтр Ф.Угдорф ийн заасан.



Бурхан танаас Түүн рүү буцаж очих замаа олоосой гэж хүсдэг бөгөөд тэр зам нь Аврагч мөн болой [Иохан 14:6-г үзнэ үү]. Бурхан та бүхнийг Өөрийнх нь Хүү Есүс Христийн талаар олж мэдэн, бурханлаг шавь байх замыг дагаснаар ирэх амар амгалан, баяр баяслыг мэдрээсэй хэмээн хүсдэг. (Дийтр Ф.Угдорф, “Гэрэл ба үнэний талаар гэрчлэл хүлээн авах нь,” *Ensign*, Nov. 2014, 21 эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 22)

- Та эсвэл таны таньдаг хэн нэгэн Есүс Христийг дагаснаар ирдэг амар амгалан, баяр баясгаланг хэзээ мэдэрч байсан бэ?
- Бид Тэнгэрлэг Эцэг рүү буцан очихын тулд ямар ямар арга замаар Аврагчийг дагаж чадах вэ?

- Бид зөв зам дээр байгаагаа хэрхэн мэдэж болох вэ?

Есүс Христ бол “усан үзмийн мод” (Иохан 15:5) юм

Есүс Христ харьцуулалтыг ашиглан Өөртэй нь харилцах харилцааных нь талаар шавь нартаа заажээ. Иохан 15:1–11-ийг уншаад, энэхүү харьцуулалтыг олж мэд. Хэрэв та өмнөх хичээлээр Есүс Христийн янз бүрийн нэр цол, үүргийн талаар жагсаалт үүсгэсэн бол уг жагсаалтдаа Иохан 15 дээр нээн илрүүлсэн зүйлсээ нэмэх боломжтой.

- Есүс Христ энэхүү харьцуулалтаар юуг зааж байна гэж та бодож байна вэ?
- Та энэхүү харьцуулалтаас Есүс Христтэй харилцах бидний харилцааны талаар ямар үнэнийг олж мэдэж болох вэ?

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд Түүн дотор байгтун гэсэн Аврагчийн урилга нь “үлдэгтүн, ... үүрд байгтун” хэмээн бидэнд өгсөн урилга болохыг тайлбарласан” (“Abide in Me,” *Ensign* эсвэл *Liahona*, May 2004, 32). Ахлагч Холланд Түүн дотор байгтун гэсэн Аврагчийн урилгыг хүлээн авах нь бидэнд яагаад ийм чухал болохыг тайлбарлажээ. Та дараах мэдэгдлийг уншиж болно.



Есүс “Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй” [Иохан 15:5] хэмээн хэлсэн билээ. Энэ бол Бурханы үнэн гэдгийг би гэрчилж байна. Христ бол бидний хувьд бүх зүйл бөгөөд бид Түүний дотор үүрд мөнхөд бат бөх, тууштай, хөдөлшгүй оршин амьдрах хэрэгтэй. Сайн мэдээний үр жимс цэцэглэн дэлгэрч, бидний амьдралыг адисалж байхын тулд бид бүхний Аврагч болсон Түүнтэй, Түүний ариун нэрийг тээдэг Сүмтэй бат бөх холбогдсон байх ёстой. Тэр бол бидний хүч чадлын жинхэнэ эх үүсвэр, мөнх амьдралын цорын ганц эх булаг болох усан үзмийн мод юм. Бид Түүний дотор зөвхөн тэвчээд зогсохгүй, ялан дийлэх бөгөөд биднийг

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ

хэзээ ч үл орхих энэ ариун үйл хэрэгт ялалт байгуулах болно. (Jeffrey R. Holland, "Abide in Me," *Ensign* эсвэл *Liahona*, May 2004, 32)

Мормоны Ном нь Шинэ Гэрээнээс суралцаж байгаа зүйлсийн тань талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд тусална. Алма 26:12-ыг уншаад, энэ нь Иохан 15:1–11-тэй хэрхэн холбогдож буйг эргэцүүлэн бод.

- Та Есүс Христ дотор байхыг хичээснээр өөрийн амьдралаас ямар үр жимсийг (үр дүн эсвэл адислал) олж харсан бэ?
- Есүс Христ дотор байхад туслах ямар ямар үйлдлийг та хийж болох вэ?